



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК



**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

2025



75114444, 77006768



www.basaltwool.mn



monbasalt@rockwool.mn



ДУЛААЛАХААС **ӨМНӨ**

ДУЛААЛСНЫ **ДАРАА**

Агуулга

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Компанийн танилцуулга

Үйл ажиллагааны тайлангийн тойм

Санхүүгийн тайлангийн тойм

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тойм


Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг өгсөн ТҮЗ-ийн дүгнэлт

Ногдол ашгийн мэдээлэл

2025 оны төлөвлөгөөт ажлын тойм

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуугас

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл





BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

"МОНГОЛ БАЗАЛЫТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр: "Монгол базальт" хувьцаат компани

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрийн бүс-1-35 тоот

Хурал болох газар: Улаанбаатар зочиг буудал, "Сонгинохайрхан" танхим /хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Самбуугийн гудамж/

Хурал болох өдөр, цаг: **2025 оны 04 сарын 30-ний өдрийн Лхагва гаригт 15.00 цагт**

Хурал болох хэлбэр: Танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: **2025 оны 04 сарын 11-ний өдөр**

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. "Монгол базальт" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын гэг
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
4. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан
5. 1. "Некса глобал монголиа аудит" ХХК-ийн аудитын дүгнэлт
6. 2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
7. 3. Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоол
8. 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал санал өгөх саналын хуудас

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай 2025 оны 03 сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10.00-16.00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, "Фламинго тауэр"-ийн 7 давхарт компанийн төв оффисын аль нэгт очиж эсхүл www.basaltwool.mn цахим хуудсаар гамжуулан танилцах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг **75114444** утсаар авч болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



МОНГОЛ БАЗАЛТЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03-р сарын 20-ны өгөр

№ 07

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Монгол Базальт" ХК-ийн гүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.4 гэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол базальт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн Лхагва гаригийн 15.00 цагт Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Самбуугийн гудамж хаягт байрлах "Улаанбаатар" зочид буудлын "Сонгинохайрхан танхим"-г танхимын хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай. -"Монгол базальт" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 03 сарын 23-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржиг тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-г даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 11-ны өгрөөр тогтоосугай.
5. "Монгол базальт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн цахим хуудас болон өгөр тутмын "Өдрийн сонин"-оор 2025 оны 03 сарын 25-ний өгөр олон нийтэд мэдээлж, зарын гавталтыг 2025 оны 04 сарын 09-ний өгөр анх зарласан хэлбэрээр гахин олон нийтэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга зэрэг баримт бичгийг 2025 оны 03 сарын 26-ны өгөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-г даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарын загварыг нэгдугаар хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, хурлын саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг, хурлын хөтөлбөрийг дөрөвдугаар хавсралтаар баталсугай
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын гаргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Нямдорж, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр О.Билгүүн, Ц.Мэнгбаяр, Б.Энхсайхан нарыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2025 оны 04 сарын 26-ний өдрийн 18.00 цаг хүртэл хугацаанд брокер гилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт байрлах компанийн төв оффист бичгээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга /П.Нямдорж/-г даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Ууганцэцэг, тооллогын комиссын гишүүдээр Б.Амаржаргал, Э.Цэрэнпагма нарыг томилсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид зааснаар Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-г даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ны өдрийн
07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн нэр
1	"Монгол базальт" ХК-ийн ТУЗ-ийн тогтоол, хавсралтуудын хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2025.03.20-ны өдрийн Дугаар 07
2	"Монгол базальт" ХК-ийн 2024 оны Үйл ажиллагааны тайлан
3	"Монгол базальт" ХК-ийн 2024 оны Санхүүгийн тайлан "Нексия глобал монголиа аудит" ХХК-ийн хөндлөнгийн аудитын дүгнэлт
4	"Монгол базальт" ХК-ийн 2024 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлт
5	"Монгол базальт" ХК-ийн Компанийн засаглалын үнэлгээний тайлан
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг тараах тухай 2025.02.19-ны өдрийн Дугаар 03 тогтоол
7	Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, түүний хувьцааны төрөл, тоо



**"МОНГОЛ БАЗАЛТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

Нийт үргэлжлэх хугацаа: 3 цаг

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
14.45-15.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
15.00-15.10	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс гарга
15.10-15.20	Хурлын үйл ажиллагааг нээж, дэгийг танилцуулах	Хурлын гарга П.Нямдорж
15.20-15.40	Монгол базальт ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл
15.40-16.00	Асуулт хариулт	
16.00-16.20	Цайны завсарлага	
16.20-16.30	ТҮЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-өөс өгсөн дүгнэлт танилцуулах	ТҮЗ-ийн хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар
16.30-16.35	Хурлаар хэлэлцэх асуудалд цахим систем ашиглан санал өгөх талаарх дэлгэрэнгүй танилцуулах – нууц дугаар үүсгэх	Хурлын гарга П.Нямдорж Тооллогын комисс Т.Ууганцэцэг
16.35-17.45	Санал хураалт – цахим	Тооллогын комисс
17.45-17.55	Санал хураалтыг нэгтгэн тоолох, танилцуулах	Тооллогын комисс
17.55-18.00	Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаах	Хурлын гарга П.Нямдорж



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**"МОНГОЛ БАЗАЛТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1. Нийтлэг үнгэслэл

1.1 Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох гүрэм журам, заавар, компанийн гүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна

2. Хурлын гарга, түүний эрх үүрэг

2.1 Хурлын гарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын гаргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.

2.2 Хурлын гарга гараах эрх, үүрэгтэй. Үүнг:

2.2.1 Хурлын гарга нь хурлын дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос хурлын дэгийг сахин биелүүлэхийг шаардах

2.2.2 Хуралд оролцогчдог асуулт асуух зөвшөөрөл олгож, асуулт асуух хугацааг чанг мөргүүлэх

2.2.3 Хуралдааны дэг зөрчсөн этгээдэг энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох

3. Хуралдаанг оролцох

3.1 Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 30 минутын өмнө бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.

3.2 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхтэй ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үнгсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг авч ирнэ.

3.3 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/-тай ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үнгсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийн эх хувийг авчирна.

3.4 Хуралд оролцогчийг гараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын танхимаас гаргана. Үүнг:

3.4.1 Хувьцаа эзэмшигч биш байх

3.4.2 Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримтгүй байх

3.4.3 Хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх

3.4.4 Хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох

3.4.5 Хурлын гаргын сануулгыг удаа гараа зөрчих

3.4.6 Зүй бус үг хэллэг хэрэглэх, бусдыг дайрч горомжлох үйлдэл гаргах

3.5 Тооллогын комисс нь энэхүү дэгийн 3.4-т заасан үнгэслэлээр тухайн этгээдийг хуралд оруулахгүй, хурлын танхимаас гаргана.

4.1. Асуулт, харуулт

- 4.1 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асууна. Асуулт асуух хугацаа 1 /нэг/ минут байна.
- 4.2 Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3 Хурал зохион байгуулагч нь асуулт асуух, хувьцаа эзэмшигчдийг гараалалд оруулан овог, нэр асуултыг тэмдэглэж авна.
- 4.4 Асуултаг компанийн эрх бүхий албан тушаалтан харуулна. Асуултаг харуулах этгээд нь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуултаг харуулахаас татгалзах эрхтэй.
- 4.5 Асуулт асуух хугацаа хэтэрсэн тохиолдолд хурлын дарга хугацаа дууссаныг сануулах бөгөөд сануулснаас хойш 30 секунд өнгөрмөгц хурлын дарга тухайн хүнийг асуултаа дуусгахыг шаардана.
- 4.6 Хувьцаа эзэмшигчид нь хуралд оролцож буй хөндлөнгийн аугимтын байгууллагын төлөөлөгчөөс асуулт асууж болох ба энэхүү дэгийг баримтална.

5. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх

- 5.1 Хуралд оролцогч нь хурлын өмнө цахим бүртгэлд бүртгүүлэн, санал өгөх заавартай танилцсан байх бөгөөд тус заавар маягтын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйг тооцно.
- 5.2 Урьдчилсан санал гэдэг нь хувьцаа эзэмшигчийн хурлын төвлөсөн өдрөөс өмнө батлагдсан саналын хуудсаар цаасаар өгсөн хувьцаа эзэмшигчийн санал байна.
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах албан ёсны зарлалд тусгагдсан бүртгэлийн өдрөөс эхлэн урьдчилсан санал өгч болно. Урьдчилсан санал өгсөн тохиолдолд түүнийг дахин өөрчлөхгүй ба тус санал нь эцсийнх байна.
- 5.4 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр өөр агуулгатай санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түргүүлж өгсөн саналыг хүчинтэйг тооцно.
- 5.5 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудал тус бүрт нэг санал өгөх эрхтэй.
- 5.6 Хэлэлцэх асуудлын баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд санал өгөхдөө саналын хуудасны арын хэсэгт бичнэ.
- 5.7 Хуралд оролцогчоос баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд өгсөн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь саналын төвбөөгт тусгана. Саналын төвбөөгт тусгахдаа тухайн хуралд оролцогчийн овог, нэр оруулах саналыг үнэн зөв, бүрэн гүйцэт тусгана.

6. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах

- 6.1 Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилогдсон тооллогын комисс тоолж, нэгтгэнэ.
- 6.2 Тооллогын комиссын дарга нь саналыг нэгтгэж хурлын даргад танилцуулна.
- 6.3 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр давхар санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар сүүлийн өгсөн саналыг хүчинтэйг тооцно.
- 6.4 Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийн тус хуралд оролцсонд тооцож бүртгэх ба саналын хуудасыг нэгтгэн тоолно.
- 6.5 Тооллогын комисс нь цахим системээр өгсөн саналыг шууд тоолж, цаасан хэлбэрээр өгсөн хүчин төгөлдөр саналыг цахим систем рүү оруулж, саналыг нэгтгэнэ.
- 6.6 Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан болон цаасан хэлбэрээр өгсөн саналыг хамт Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт архивлана.

7. Харууллага

- 7.1 Хуралдааны дэг зөрчигчид хуралдаан даргалагч нь эхний удаа сануулна
- 7.2 Удаа дараа зөрчвөл хурлын танхимаас гаргана.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Өсөлт, хөгжил ба шинэ боломжууд

Эрхэм хүндэт харилцагч та бүхэндээ,


Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх захирлын хувьд компанийнхаа өнгөрсөн жилийн амжилтыг та бүхэнтэй хуваалцаж байгаагаа баяртай байна.

Бид тогтвортой өсөлтийг хаггалж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, шинэ зах зээлд нэвтэрч байна. Энэ нь зөвхөн манай хамт олны хүчин чармайлтын үр дүн биш, олон гадна гомны хамтарсан хөтөлбөр зэрэг гадаад түншүүдтэйгээ үр бүтээлтэй хамтран ажилласны үр шим юм.

Бид үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж, бүтээгдэхүүний өртгийг бууруулж чадсанаар зах зээлд өрсөлдөх чадвараа улам бэхжүүлж байна. Гэхдээ бид зөвхөн ашгийн төлөө бус, хариуцлагатай, тогтвортой бизнесийн зарчмуудыг баримталдаг. ESG үнэлгээ, ISO стандартууд нь үүнийг нотолж байна.

Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, зах зээлээ тэлэх нь бидний гол зорилтуудын нэг. Мөн бид үндэсний их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, барилгын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, инновацийг дэмжихэд хувь нэмрээ оруулж байна. Монгол Базальт ХК нь зөвхөн өнөөдрийн амжилтаар зогсохгүй, цаашид улам хөгжин дэвших, Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулах болно.

А.Энхгэрэл



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Ирээдүйг хамтгаа бүтээцгээ

**Эрхэм хүндэт ажилчиг, туншүүг,
хувьцаа эзэмшигчиг ээ,**

Монгол Базальт ХК-ийн ТУЗ-ийн даргын
хувьд та бүхэндээ мэндчилгээ
гэвшүүлье.

Бид хамтгаа гайхалтай зүйлийг бүтээж байна. Манай компани тогтвортой өсөлтийг харуулж, инноваци, байгаль орчинг ээлтэй үйл ажиллагаагаараа салбартаа тэргүүлэгч хэвээр байна. Энэ нь зөвхөн санхүүгийн үзүүлэлтээр хэмжигдэхгүй, харин бидний нийгэм, байгаль орчинг үзүүлэх эерэг нөлөөллөөр батлагдаж байна.

Бидний баримталдаг гол зарчим бол чанар болон бүтээмж юм. ISO сертификатууд нь үүний баталгаа юм. Гэхдээ чанар гэдэг зөвхөн бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй. Ажилчдынхаа аюулгүй байдал, эрүүл мэнд, хөгжил, нийгмийн хариуцлага гээд бүхий л үйл ажиллагаандаа бид чанарыг эрхэмлэдэг.

Бид хариуцлагатай үйлдвэрлэгч, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулагч байхыг зорьдог. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, барилгын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зэрэг нь бидний нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын нэгээхэн хэсэг юм.

Цаашид ч бид хамтгаа илүү ихийг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Л.Ариунболд





КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Байгуулагдсан огноо:

2007

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn

[Mongol Basalt JSC](https://www.facebook.com/MongolBasaltJSC)

Үйл ажиллагааны чиглэл:

Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрлэл

Хаяг:

Монгол улс,
Улаанбаатар хот,
Сүхбаатар гүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 7 давхар

Утас, u-майл хаяг:

75114444

monbasalt@rockwool.mn

Үйлдвэрийн хүчин чадал:

Цагт 2.5 мн



Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн гарга:

Л.Ариунболг

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

80



Хувьцааны мэдээлэл

Хувьцааны символ код:

MSE:MBW / 544

МХБуржиг бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан хувьцаа:

56,417,000 ширхэг

БИДНИЙ ТУХАЙ

"МОНГОЛ БАЗАЛТ" ХК нь Монголын хүнг аж үйлдвэрийн салбараас анхны Байгаль орчин нийгэм засаглалын үнэлгээ /ESG/ хийлгэсэн, дэлхийн аж үйлдвэрийн IV хувьсгал, хөгжлийн тэргүүлэх чиглэлд судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж, шинэ технологи, инновацийн шийдэл бүхий үйлдвэрлэлийг нэвтрүүлэн, хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хүлэмжийн хий, агаарын бохирдол, эрчим хүчний зардал, дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр олон зорилтот төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний томоохон үйлдвэрлэгч юм.



БАЗАЛТ чулууны 7 гайхамшиг : Бидний бүтээгдэхүүний цөмг байгалийн чулууны хүч оршино.



Бид галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг бий болгох шинэ боломжийг үргэлж эрэлхийлдэг.



Эрхэм зорилго

Монголдоо Ногоон барилгын бүтээн байгуулалтын чанар стандартыг хөгжүүлнэ:

Базальт чулуунаас үйлдвэрлэгдэх бүхий л инновацийн технологийг нутагшуулна.

Тогтвортой хөгжлийг түүчээлнэ: Үндэсний хэмжээнд байгаль орчинд ээлтэй барилгын түршлэгүүдийг нэвтрүүлж, CO2 үл мөр бага үйлдвэрлэлийг дэмжинэ.

Бие гаасан, хараат бус Эргэлтэт Эдийн

Засгийн бүтээлцэнэ: Импортын бүтээгдэхүүнээс хараат байдлыг зогсоож, үндэсний аж үйлдвэрүүдийн дэмжих бодлогыг идэвхижүүлнэ.



Алсын хараа

Ирээдүй хойч үедээ үлдээх, Эрүүл Ногоон

Хотын төлөө: Монголынхоо хөрсөнд бойжсон галт уулын БАЗАЛТ чулууны гайхамшигийг хамгийн орчин цагийн Инноваци Технологиор нээж, ЭРЧИМ ХҮЧНИЙ хараат бус, ГАЛ, УСНЫ эрсдэлгүй, Тогтвортой, Тэсвэртэй Ногоон Хотыг бүтээлцэнэ.

Нэгдсэн удирдлагын Бодлого (IMS)

Инновацийг Түүчээлнэ: Бид Монголын дулаалгын үйлдвэрлэлийн салбарт хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн болон процесс нэвтрүүлнэ.

Ямагт Тэргүүлэх ЧАНАР: Бид чулуун хөвөн дулаалгын үндэсний стандартыг тогтооно.

Оролцогч талуудын үнэ цэнэ: Бид хөрөнгө оруулагч, харилцагч, ажилчид болон улсын нийгмийн хэрэгцээг нэн тэргүүнд тавина.

Байгаль орчны менежмент: Бид хойч үедээ зориулж Монголын байгалийн баялгийг хамгаална.


БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөрсөн 17 жилийн турш биг өөрсдийн know-how болон мятрашгүй хөгжих хүсэл элмэлзэлээ, хийсэн бүхэндээ шингээж ирсэн. Бидний үүсгэн байгуулагч нар болон хамт олон хуучин арга техникийг тогтмол сорин, шинэлэг санааг туршин хөгжүүлдэгийн үр гүнг биг өнөөдөр байгалийн ганц чулуунаас олон төрлийн гэвшилтэт шийдлүүдийг гарган авсан байна.


Дэлхий дээрх бүх галт уулын чулуулгийн 90 гаруй хувь нь базальт юм. Базальт нь ихэвчлэн цахиур, төмөр, магни, кали, хөнгөн цагаан, титан, кальцийн оксидуудаас бүрддэг. Базальт чулууг цельсийн 2000 градусын температурт хайлуулж базальт чулуун хөвөн гулаан тусгаарлагч материалыг үйлдвэрлэдэг тул энэхүү материал нь 100% байгалийн гаралтай, байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, Монгол улсаас ОУ-ын галын А1 зэрэглэлд ордог цор ганц бүтээгдэхүүн юм.

Компани өөрийн уурхайгаас олборлосон түүхий эг Базальт чулууг ашиглан 30-150 кг/м³ эзэлхүүний масстай, 0,032-0,048 Вт/м гулаан дамжуулалтын итгэлцүүр бүхий 4 төрлийн гулаан тусгаарлагч бүтээгдэхүүн, базальт фибер арматур, нийт 4 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



BASALTWOOL

чулуун хөвөн гулаан тусгаарлагч материал



BASALT REBAR

базальт фибер арматур



BASALT SANDWICH BOARD

базальт хэсэгчилэн угсрах кассет сэндвич хавтан



SPRAY BASALT

Шүршдэг болон үртсэн базальт гулаан тусгаарлагч материал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байхаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд цаашид Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах, хэвшүүлэх, тогтвортой байдлыг бий болгох зорилттойгоор ажиллана.

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөл ээлжит 4 хурал, эчнээ санал хураалт 2 удаа хийж 10 тогтоол гаргасан байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Базальт ХК 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дугаар сарын 29-ний өдөр 80% ирцтэйгээр зохион байгууллаа.

1 ТҮЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Л.Ариунболг



Б.Шаравсамбуу



Хан Гю Бунг



П.Сайнбилэг



Г.Ганзориг



А.Энхгэрэл



Ш.Энхтөр



П.Нямгорж



Ч.Зоригтбаатар

2

"КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС" ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Кодексын зарчим	Авбал зохих оноо	Үнэлгээ	Үнэлгээний хувь
ТҮЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
ТҮЗ-ийн дэргэдэх хороог тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
Тайлагнал, мэдээллийн ил тог байдал	6	6	100%
Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
Эрсдлийн удирдлага	8	8	87.5%
Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
Компанийн соёл	6	6	100%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
Нэгдсэн дүн	72	72	

2024 оны компанийн
засаглалын кодексын
ҮНЭЛГЭЭ:

100%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ ХАНШ

Хаалтын ханш
/2024.12.31/


+5.84₮

192₮

197.84₮

Өмнөх ханш
/2023.12.31/

ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК



Олгосон ногдол ашиг


Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашиг т эзлэх %	Нэгж хувьцаа нг ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000	68%	4.00	2%
2020	162,480,960	100%	2.88	2%
2021	964,166,530	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000	53.4%	20	9%
2023	1,184,757,000	96.1%	21₮	10.2%

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны гээг ханш нь 206₮, дооо ханш нь 170.42₮ бөгөөд 2024 оны хаалтын ханш 197.84₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сарг гунджаар 144.5 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршиг нийт 1734 мянган ширхэг хувьцаа 318.5 сая төгрөгөөр арилжаалагдлаа.


Мөн тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолг 2024 оны 02 сарын 23-ны өгөр өөрчлөлт оруулсантай холбогдуулан 2023 оны ногдол ашиг болох 1,184,757,000 төгрөгийг ҮЦТХТ ХХК-р дамжуулан хувьцаа эзэмшигчдийн гансанг 2024 оны 05 сарын 31-ний өгөр тараан байршууллаа.

Ногдол ашгийн өсөлт /₮/



1

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



- 5%-иас дээш хувьцаа эзэмшигчиг
- 5%-иас доош хувьцаа эзэмшигчиг

2

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭШИГЧИД

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболг	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол базальт ХК-ийн гулаан тусгаарлагч материалын үйлгвэр нь 2024 онд 2892,5 тонн хөвөн үйлгвэрлэлээ.

Чулуун хөвөн гулаан тусгаарлагч материалын үйлгвэрт их бүтээн байгуулалт засвар шинэчлэлийн ажил өрнүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



ЭКСПОРТ

Тайвань улсруу бүтээгдэхүүн экспортоллоо.”

Монгол Базальт ХК нь 2024 оны 05 сард Тайвань улсын CHRONG YI COMPOSITE компанитай Базальт файбер бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан ба гэрээний дагуу 2024 оны 3 дугаар улиралд бүтээгдэхүүнээ Тайвань улсын Таювань хотруу амжилттай экспортоллоо.



НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

“МонСертф” ХХК-ийн 3 аудитор 2 шатны аудит хийсэний үндсэн дээр “Монгол базальт” ХК-ийн “Чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлгвэрлэл, худалгаа” хамрах хүрээнд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлснийг баталгаажуулсан анхдагч гэрчилгээг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар олголоо.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тогтвортой санхүүжилтийн холбоонг гишүүнээр элслээ.

Монгол улсад анхны чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулсан Mongol Basalt JSC нь компанийн философийн цөмөөр Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалууд нягт уялдаатай ажлууд хийдэг билээ. 2014 онд гэр хорооллын айлуудын гахин дулаалгын аянууд санаачласнаас гадны барилгын салбарын эрчим хүчний хэрэглээг бууруулах, агаар манглын нүүрсхүчлийн хийг бууруулах, тойрог эдийн засгийг хэрэгжүүлэхээр BASALTCycle хөтөлбөр зэргийг идэвхтэйгээр хэрэгжүүлж байгаа. Холбоонг нэгдэн орсноор Тогтвортой хөгжлийн зорилтуудаг хувь нэмрээ оруулж, нийгэмд тулгарч буй үүр амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аюулгүй, эрүүл, үүр амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг цогцлоох эрхэм зорилготой байгаа билээ.

Барилгын Дэлхийн холбоо (GlobalABC)-г гишүүнээр элслээ.

GlobalABC нь олон улсын, олон талт түншлэл бөгөөд янз бүрийн платформ, санаачлага, оролцогчдын хамтарсан байгууллага юм. Энэ нь Парисын хэлэлцээрийн зорилтуудын дагуу хамтын ажиллагааг бий болгох, үүр амьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх, барилга байгууламж, барилгын салбарын уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Монгол Базальт ХК нь шинэ гишүүний хувьд мэдээллийн хүртээмж, байгууллагын чадавхи, бодлогын хүрээ, санаачлагын зохицуулалт, санхүүжилтийн механизм зэрэг гол сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байна. GlobalABC нийгэмлэгтэй хүчээ нэгтгэснээр бид салбарын нөлөөллийг бууруулах, гасан зохицох чадавхийг ашиглаж, утаагүй, үр ашигтай, уян хатан барилгуудыг хүн бүрт гэмжих зорилготой.



БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ


Монгол Базальт ХК нь 2023 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын материаллаг байдлын үнэлгээг "Ризилиенс Консалтинг Сервиз" ХХК -р гүйцэтгүүлж, компанийнхаа БОНЗ-ын асуудлуудыг нарийн тогдорхойлж үнэлсэн.



БОНЗ-ЫН БОДЛОГО



Тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба нийлүүлэлт



Тогтвортой үйл ажиллагаа



Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал

2024 оны Байгаль орчны онцлох үзүүлэлтүүд:



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

2023 ОН 927,139 кВт/цаг	2024 ОН 849,877 кВт/цаг	БУУРАЛТ 8.3% ↓
-------------------------------	-------------------------------	-------------------



УСНЫ ХЭРЭГЛЭЭ

2023 ОН 3,993м3	2024 ОН 4689м3	ӨСӨЛТ 14.9% ↑
--------------------	-------------------	------------------



ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭ

2023 ОН 176,284 л	2024 ОН 195,946 л	ӨСӨЛТ 11.1 ↑
----------------------	----------------------	-----------------



ХОГ ХАЯГДАЛ -ЭНГИЙН

2023 ОН 325 тн	2024 ОН 468.9тн	ӨСӨЛТ 15% ↑
-------------------	--------------------	----------------



ХОГ ХАЯГДАЛ -АЮУЛТАЙ

2023 ОН 120 кг	2024 ОН 140 кг	ӨСӨЛТ 16.6% ↑
-------------------	-------------------	------------------



ДУЛААН ХАНГАМЖ

2023 ОН 2158 Гж	2024 ОН 1882 Гж	БУУРАЛТ 14.6% ↓
--------------------	--------------------	--------------------

2024 онд Нийт 3 худалдан авагч байгууллагаас 1306 кг чулуун хөвөнгийн хаягдал 25кг багтаа боодлын хаягдал буцаан авсан.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЙМ

Үйлдвэрлэлийн шинэчлэл инновацийн үр дүнд чулуун хөвөн хавтангийн борлуулалтын үнээ **30-40%** бууруулан хэрэглэгчдэд хүргэж байна. 2024 оны мөн үетэй харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний тоо өсч, борлуулалтын орлого **22.3%** өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Базальт ХК нь 2024 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд **310 мянга** орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Монгол Базальт ХК нь 2024 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд **2892.5** тн орчим бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 49.7%-ийг базальт лайт, 19.1%-ийг базальт хауз, 16.9%-ийг базальт вэнт фасадад, 14.3%-ийг базальт техно стандарт марк тус тус эзэлж байна.

BASALTCUP НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

Монгол Базальт ХК нь Монгол улс дахь хоккейн спортыг хөгжүүлэх зорилгоор хүүхэд залуучуудын дунд "BASALT HOCKEY CUP" тэмцээнийг зохион байгуулж, гэмжин ажилладаг ба нийгмийн харууцлагын хүрээнд тамирчин, суралцагч нарт тэтгэлэг олгох шийдвэрт үндэслэн Монголын хоккейн Үндэсний шигшээ багийн тамирчин Д.Лхагвадорж, Д.Цэнгэл нар Канадын Онтарио мужийн коллежийн "Crystal Beach" багт уригдаж суралцан тоглох тэтгэлэг авсанд нь баяр хүргэж тус бүр 4000 канад долларын тэтгэлэгийг онгоцны тийзийн хамт олгов.

Санхүүгийн үзүүлэлт

График 1. тэрбум төгрөгөөр




График 2. тэрбум төгрөгөөр




График 3. тэрбум төгрөгөөр




График 4. Бооглын тоогоор



График 5. тэрбум төгрөгөөр



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ БАЗАЛЪТ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Монгол Базальт ХК (цаашид “Компани” гэх)—ийн 2024 оны 12 дугаар сарын 31—ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31—ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)—ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)—уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”—ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС—ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”—ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:




У.НАРАНДӨЛГЭР
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр

МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2024	2023
Борлуулалтын орлого	6	12,275,103	10,019,108
Борлуулалтын өртөг	7	(8,975,800)	(6,736,199)
Нийт ашиг		3,299,303	3,282,909
Бусад орлого	8	996	57,977
Бусад олз / (гарз)	9	(7,583)	(35,091)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(1,199,691)	(905,602)
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(335,891)	(444,069)
Бусад зардал	10	(302,027)	(130,082)
Үйл ажиллагааны ашиг		1,455,107	1,826,042
Хүүний орлого	13	200,399	78,985
Санхүүгийн зардал	13	(1,469,341)	(539,862)
Татварын өмнөх ашиг		186,165	1,365,165
Орлогын татварын зардал	23	(49,516)	(157,571)
ЦЭВЭР АШИГ		136,649	1,207,594
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	-	1,692,335
Бусад дэлгэрэнгүй орлого		-	1,692,335
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		136,649	2,899,929
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (төгрөгөөр)		2.42	21.40

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2024-12-31	2023-12-31
ХӨРӨНГӨ			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	14	21,961	5,729,845
Дансны авлага	15	455,936	11,528
Бусад авлага	16	204,983	553,104
Бараа материал	17	3,772,558	3,087,190
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	18	2,206,637	2,987,446
Нийт эргэлтийн хөрөнгө		6,662,075	12,369,113
Үндсэн хөрөнгө	19	24,972,601	20,045,056
Биет бус хөрөнгө	20	11,408,415	11,911,039
Хойшлогдсон татварын хөрөнгө	23.2	5,755	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		36,386,771	31,956,095
НИЙТ ХӨРӨНГӨ		43,048,846	44,325,208
ӨР ТӨЛБӨР			
Дансны өр төлбөр	21	458,910	245,144
Бусад өр төлбөр	22	702,345	732,924
Орлогын татварын өр төлбөр	23.1	106,793	101,514
Бусад татварын өр төлбөр	24	2,214,595	1,207,573
Богино хугацаат зээл	25	3,837,317	2,735,501
Урьдчилж олсон орлого	26	124,782	488,447
Нөөц өр төлбөр	27	749,590	742,278
Цалингийн өр төлбөр	28	5,262	575
Нийт богино хугацаат өр төлбөр		8,199,594	6,253,956
Урт хугацаат зээл	25	3,833,857	6,268,499
Хойшлогдсон татварын өр төлбөр	23.2	614	-
Нийт урт хугацаат өр төлбөр		3,834,471	6,268,499
НИЙТ ӨР ТӨЛБӨР		12,034,065	12,522,455
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	29	5,641,700	5,641,700
Нэмж төлөгдсөн капитал	29.1	20,509,765	20,509,765
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		3,121,609	3,121,609
Хуримтлагдсан ашиг	29.2	1,741,707	2,529,680
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		31,014,781	31,802,754
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		43,048,846	44,325,208

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 19-ны өгөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4 заалт, 47 дугаар зүйлийн 47.1 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дах заалт, "Монгол Базальт" ХК-ийн гүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.6.12 дах заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02-р сарын 19-ны өгрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол базальт" ХК-ийн 2024 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн мэтварын гараах цэвэр ашиг болох 136,648,693.08 төгрөгөөс нэгж хувьцаанд 2.42 төгрөг буюу нийт 136,529,140 төгрөгийн ногдол ашгийг хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өгрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өгөр байхаар тогтоосугай.

3. Компанийн нийт гаргасан хувьцааны үндсэн 70% /39,491,900 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компаниас, олон нийтэд нээлттэй 30% /16,925,100 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд 2025 оны 04 сарын 30-ний өгрийн готор олгохыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-г зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-г даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

МОНГОЛ БАЗАЛЬТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 26-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 гэх заалт, Компанийн гүрмийн 6-р бүлгийн 6.2.6.5 дах заалт, "Монгол Базальт" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол Базальт" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нэгдугаар хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



"МОНГОЛ БАЗАЛТ" ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

"Монгол базальт" ХК нь урт хугацааны судалгаа шинжилгээ, инноваци хөгжүүлэлт, тогтвортой өсөлтийг харуулж, байгаль орчинг ээлтэй үйл ажиллагаагаараа салбартаа тэргүүлэгч хэвээр байна. Энэ нь зөвхөн санхүүгийн үзүүлэлтээр хэмжигдэхгүй бөгөөд бидний нийгэм, байгаль орчинг үзүүлэх эерэг нөлөөллөөр батлагдаж байгаа юм.

Бид харууцлагатай үйлдвэрлэгч байж, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулагч байхыг зорьж, бүхий л үйл ажиллагаандаа чанарыг эрхэмлэн ажиллаж ирсэн бөгөөд 2024 онг бодитоор баталгаажуулж Нэгдсэн менежментийн тогтолцооны ISO9001:2015, ISO 14001:2015, ISO45001:2018 стандартуудын шаардлага хангасан хамт олон болж чадсан.

"Монгол базальт" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хууль, компанийн дүрмийг удирдлага болгон 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэлт хийн, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Манай үйлдвэр 2024 онг нийт 146,000 хүн/цаг ажиллаж 2892.5 тонн чулуун хөвөн, 8456 метр шугам хоолойн гулаалга, 1084.2 метр оёмол хөнжил бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба 12.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 8.9 тэрбум төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй, 3.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан болно.

Бид зөвхөн үйлдвэрлэгч бус технологи хөгжүүлэгч байхаг анхаарч ирсэн бөгөөд Нийслэл хотын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинг амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд бодит гэмжлэг үзүүлж чадахуйц томоохон зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаагаас гурьдвал:

- НҮБ-ын "Даян гэлхийн гэрээ" болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд үүрэг, амлалт хүлээн нэгдэн орохоор зэхэж, бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг хангах "Тогтвортой хөгжлийн схем"-ийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Компанийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь Тогтвортой хөгжлийн 17 зорилтуудын 12 хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж байна.
- Парисын хэлэлцээрийн зорилтуудын гагуу хамтын ажиллагааг бий болгох, уур амьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх, барилга байгууламж, барилгын салбарын уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилгот бүхий GlobalABC олон улсын эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын холбооны Монгол улсын анхны гишүүнээр элссэн. GlobalABC нийгэмлэгтэй хүчээ нэгтгэснээр бид салбарын байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, гасан зохицох чадавхийг ашиглаж, утаагүй, үр ашигтай, уян хатан барилгыг хүн бүрт хүргэх зорилгын хэрэгжилтийг хурдасгах боломжтой болно.
- Байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, дугуй /recycle/ эдийн засгийн зарчимд нийцүүлэх зорилготой чулуун хөвөнгийн хаягдлыг гахин боловсруулах "BASALTCYCLE" хөтөлбөрийг эхлүүлсэн.

- Стратеги зорилгодоо хүрч, тогтвортой өсөлтийг бий болгох үнэт зүйлсийн нэг бол хүний нөөц, түүний тогтвортой байдлыг хангах хөтөлбөр бөгөөд компани ажилтнуудын сургалт хөгжүүлэлт, мэргэшүүлэн бэлтгэх, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Мөн ирээдүйн залгамж халаа болсон оюутан залуус, багш судлаач, инженерүүдийн мэдрэг, үр чадвар, инженерчлэлийн оновчтой шийдлийг гэмжих, судалгааны ажлын үр гүнг түгээн дэлгэрүүлэх, бизнесийн байгууллага - их, дээд сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий "МОНГОЛ ИНЖЕНЕР-2024" нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд CAD/CAE/CAM улсын олимпиадыг амжилттай зохион байгуулсан болно.
- Нийслэл, хотуудын агаарын бохирдол, эрчим хүчний хэрэглээг багасгаж, иргэдийн орлогог суурилсан орон сууцыг бий болгох зорилгоор пассив хаусны үгсармал бэлдэцийн үйлдвэрийг 2024 оны дөрөвдүгээр улиралд ашиглалтад оруулаа. Энэ үйлдвэр нь Пассив байшин барих 30см чулуун хөвөн гулаан тусгаарлагчтай, хана, дээвэр шалны хавтанг үйлдвэрлэх бөгөөд зураг төслийн гагуу шууг үгсрах боломжтой хурдан хугацаанд гулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцтай болох боломж юм.

Компанийн борлуулалтын орлого өнгөрсөн оноос 22.4 хувиар өссөн байгаа ч цэвэр ашиг багассан нь 2024 онд стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах олон талт зардлуудыг гаргаснаас гадна эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци, эрчим хүчний үнэ ханшны огцом өсөлт зэргээс шалтгаалсан гэж ТҮЗ үзэж байна. Тухайлбал: Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үндсэн үйлдвэрийн өртөг зардлыг бууруулах өргөтгөл шинэчлэл хийх болон инновац шингэсэн пассив байшингийн бүтээц хийцийн үйлдвэр, цементтэй шүршдэг базальтын үйлдвэрийн бүтээн байгуулалтуудад нийт 7.1 тэрбум төгрөг, өрсөлдөхүйц чадварлаг инженер техникийн ажилтнууд татах, сургаж хөгжүүлэх болон цалингийн зардалд нийт 2.5 тэрбум төгрөг, зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлтөг 8.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Манай улсын төр засгийн үндэсний үйлдвэрлэлийг гэмжих, гомоодын зах зээлийн хамгаалалтын бодлого хангалтгүй, тогтворгүй байгаагаас шалтгаалан бид гадны улсын чанар, стандартын шаардлага хангаагүй хямд үнэ бүхий шаарган хөвөн, шилэн хөвөн бүтээгдэхүүнтэй өрсөлдөж өнөөдрийг хүрсэн ба цаашид үүсч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тэсвэрлэх, гаван туулахтай холбогдуулан байнгын хөгжүүлэлт хийж бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж байгаа гэдгийг дурьдах нь зүйтэй.

Компанийн ТҮЗ, гүйцэтгэх захирлын харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа нь засаглалын шинэчлэлтийг бий болгож, үр гүнг нь Компанийн засаглалын кодексын зарчмуудад нийцэж ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны "Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний зэрэглэл"-д 93 хувь буюу 109 хувьцаат компаниас наймдугаарт эрэмблэгдсэн болно.

"Монгол Базальт" ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь компанийн гунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангаж, цаг үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийж "хангалттай сайн" ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2025 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

Шинэ үйлдвэрийн төсөл, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Монгол Базальт компанийн үйл ажиллагааны үр ашгийг гээшлүүлэх, гулаалгын зах зээлд гээрх байр сууриа бэхжүүлэх стратегийн зорилтын дагуу 2025 оны эцэс гэхэд 30000тн/жил хүчин чадал бүхий шинэ үйлдвэр барихаар төлөвлөж байна.



Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт

2024 оны 3 дугаар улиралд Пассив базальт панель хийц амины орон сууцны 30 см зузаан базальт чулуун хөвөн гулаан тусгаарлагчтай хана, шал таазны бүтээц хийцийн үйлдвэрлэлийн төслийг эхлүүлсэн ба үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн угсралт тохируулгын ажлыг 2025 оны эхний улиралд хийж ажиллана. бүтээгдэхүүнийг 2025 оны 2 дугаар улирлаас борлуулж эхлэхээр төлөвлөөд байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө

Чулуун хөвөн үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан тогтмол хугацаанд их засвар үйлчилгээ хийх шаардлагатай тул засварын горимд нийцүүлэн 1, 2-р сард үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, угсралт, урсгал засварын ажлыг хийж бусад саруудад үйлдвэр хэвийн ажиллах ба 2025 онд 3997 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

График . Үйлдвэрлэл /бүтээгдэхүүний төрлөөр/



БИЗНЕС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 онд дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран үйлдвэрийн шинэчлэл, техник, технологийн инноваци нэвтрүүлэх, компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой хэд хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөг байна.

Төслийн нэр	Хамтран ажиллах байгууллага	Хамтран ажиллах хэлбэр
ISO 9001, 14001, 45001 стандарт, нэгдсэн удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх	Монсертф ХХК	НМТ-ны магадлан аугим хийлгэх
Базальт чулуун хөвөнгийн 2 дахь үйлдвэрийн төсөл	Европын сэргээн босголт хөгжлийн банк	Зөвлөх үйлчилгээ

ХЭСЭГЧЛЭН УГСРАХ БАЗАЛТ СЭНДВИЧ ХАВТАНГИЙН ҮЙЛДВЭР

Базальтвүүл чулуун хөвөнтэй хэсэгчилэн угсрах сэндвич шинэ технологи: Энэхүү технологи нь барилгын металл хийцийг хөнгөрүүлж, угсралтын ажлыг хөнгөн хурдан шуурхай болгохоос гадна дизайн фасадны шийдлийг хэрэглэгчид чөлөөтэй сонгох боломжийг олгодогдоороо гадуу талтай. Угсармал хийцийн хооронд нягт зөөлөн холбоотой тул гулааны алдагдалгүй, гадна фасадны өргөн сонголтоор хийснээр оффис, худалгааны төв, спорт заал, зэрэг хотын өнгө үзэмжтэй хосолсон, галын аюулгүй барилга байгууламж барих боломжийг бий болгохыг зорин ажиллаж байна.


ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 онд дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, агаар, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилготой хэд хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөг байна.


Төслийн нэр	Хамтран ажиллах байгууллага	Хамтран ажиллах хэлбэр
ЭСКО төсөл боловсруулах, хэрэгжүүлэх,	ОУ-н байгууллага, Дулааны, цахилгааны станц, иргэд	Гэр хорооллын 5000 айл дахин дулаалах төслийг боловсруулах, хэрэгжүүлэх
ЭСКО-Ногоон бонд, койн гаргах	ОУ-н байгууллага, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага	Гэр хорооллын дахин дулаалгын төслийн хөрөнгө санхүүгийн эх үүсвэрт ашиглана
“Улаанбаатар хотын угсармал орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь”	НАМА, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Барилга, хот байгуулалтын яам, Даян гэлхийн байгаль орчны сан	Дулаалгын материал нийлүүлэх
Сургалт	Улаанбаатар хотын агаар орчны бохирдлын эсрэг газар, Дүүрэг, хороогуудын удирдлагууд	Дахин дулаалгын сургалт хамтран зохион байгуулах
Дулаан шийдэл 2 төсөл	Жерес ОУТББ	бүтээгдэхүүн нийлүүлэх

САНХҮҮ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Борлуулалтын орлого /гэрбум MNT/




ББӨ /гэрбум MNT/




Тайлбар: Чулуун хөвөн хавтангийн борлуулалтыг идэвхжүүлэхээс гадна бусад нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шугамыг ашиглалтанг оруулж борлуулалтын орлогыг 50%-60% нэмэгдүүлнэ.

Нийт ашиг /гэрбум MNT/




Цэвэр ашиг /гэрбум MNT/



Тайлбар: Нийт ашгийг 28-30% түвшинг байлгах, цэвэр ашгийг өмнөх оны мөн үеэс нэмэгдүүлэх зорилт тавин зардалын хяналтыг сайжруулан ажиллана.


Нийт хөрөнгө /гэрбум MNT/



Богино хугацаат өр төлбөр /гэрбум MNT/



Тайлбар: Үйлдвэрийн шугамын шинэчлэл, капиталжуулалтын ажлыг өрнүүлж нийт хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ. Богино хугацаат зээл болон бусад санхүүжилтээр эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоно.



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ны өдрийн
07 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



**"МОНГОЛ БАЗАЛТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

**"Монгол базальт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 30-
ний өдрийн Лхагва гаригийн 15.00 цагт**

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түгээлзсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн дүгнэлтийг батлах			

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /
Санал авах хуугас үйлдсэн: 2024 оны ___ сарын ___ өгөр

Саналын хуугасыг хүчинтэйг тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын гарга _____ /Т.Ууганцэцэг/

Саналын хуугасыг хүчингүйг тооцсон шалтгаан: _____

Санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуугасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ /+/ тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь:
Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд /+/ тэмдэглэгээ хийнэ.
- Санал авах хуугасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг гаран баталгаажуулж хувьцаа
эзэмшигчдэд өгнө.
- Засварласан, балласан залруулагатай санал авах хуугас нь хүчингүйг тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 04 сарын 26-ний дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн
биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2024 оны 04 сарын 26-ний 18.00 цагаас өмнө санал авах хуугасанг
саналаа тэмдэгдлэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

Төсөл

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 30-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг
Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн гүрмийн 6 дугаар бүлгийн 6.1.5.11 дэх хэсэг, 2025 оны 04 сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.


ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

*Маргаашийн хөгжил дэвшлийг
өнөөдөр хамтдаа бүтээнэ.*



 75114444, 77006768

 www.basaltwool.mn

 monbasalt@rockwool.mn